



Оюу Толгой ХХК

Орон нутгийн харилцааны хэлтэс

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

Товчилсон үгийн жагсаалт

ГСӨСТ	Говийн соёлын өвийн судалгааны төв
ГХЗ	Газар хөндөх зөвшөөрөл
СДЗОТБХ	Соёлын дурсгалт зүйлс олдсон тохиолдолд баримтлах журам
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
МСӨОУБ	Монголын соёлын өвийн олон улсын баг
ОНХХ	Орон нутгийн харилцааны хэлтэс
ОТ	Оюу толгой
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
СӨ	Соёлын өв
СӨДГХТ	Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөө
СӨХ	Соёлын өвийн хөтөлбөр
СӨДГХТ	Соёлын өвийн дурсгалт газрыг хамгаалах төлөвлөгөө
СӨУТ	Соёлын өвийн удирдлагын тогтолцоо
СӨУС	Соёлын өвийн удирдлагын систем
ХАГ	Хамтын ажиллагааны гэрээ
ХДС	Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан
ШНБ	Шууд нөлөөллийн бүс
ШБНБ	Шууд бус нөлөөллийн бүс
ШУА	Шинжлэх ухааны академи
ЭМААБО	Эрүүл мэнд байгаль орчин
ЭМААБООН	Эрүүл мэнд байгаль орчин орон нутаг

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

АГУУЛГА

Хүснэгтийн жагсаалт	3
1. ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Зорилго.....	4
1.2 Хэрэглээ	4
1.3 Эхлэх хугацаа.....	4
1.4 Эрх, удирдлага.....	4
2 ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ.....	5
2.2. Соёлын өв – Тодорхойлолт	5
2.3. СӨУТ-нд орсон соёлын өвийн төрлүүд	5
2.4. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал.....	6
3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	7
3.1. СӨУТ- ний хэрэгжилтийг хариуцах гол албан тушаалтан, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг.....	7
3.2. Соёлын өвийн гол оролцогч талууд.....	8
3.3. Гол үүрэг гүйцэтгэгчид.....	15
3.4. Холбогдох стандартуудын тойм	15
3.5. Хамтын ажиллагааны гэрээний соёлын өвтэй холбоотой үүрэг амлалтууд	16
3.6. Хамтын ажиллагааны Нэмэлт хавсралт 7: Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал.....	16
3.7. Соёлын өвийн удирдлагын тогтолцоо	18
3.8. Соёлын өвийн хөтөлбөр	18
4. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	19
4. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	18
4.2. СӨУТ-г хянах, өөрчлөлт оруулах.....	18
6. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	21
6.1. Мониторингийн шаардлагуудын тойм.....	21
6.2. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд.....	21
6.3. Хяналт шинжилгээний үндсэн үйл ажиллагаа.....	23
7. СУРГАЛТ	25
7.1. Танилцуулах сургалт	25
7.2. Ажлын байрны чиглэлээр явуулах тусгайлсан сургалт.....	25
8. АУДИТ БОЛОН ТАЙЛАН	25
8.1. Дотоод аудит.....	25
8.2. Хөндлөнгийн аудит	26
8.3. Бүртгэл хөтөлөлт	26
8. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ	27

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.ХАРИУЦАХ ГОЛ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ	7
Хүснэгт 2. Соёлын өвийн гол оролцогч талууд.....	8
Хүснэгт 3. Соёлын өвийн ХОЛБОГДОХ СТАНДАРТУУД.....	15
Хүснэгт 4. Соёлын өвийн удирдлагын ҮНДСЭН ХЯНАЛТУУД	19
Хүснэгт 5. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ҮЕ ШАТУУД	18
Хүснэгт 6. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	21
Хүснэгт 7. Хяналт шинжилгээний үндсэн үйл ажиллагаа.....	23

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Энэхүү Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө (СӨУТ)-нь дараах зорилготой болно. Үүнд:

- СӨУТ-ний хамрах хүрээг баталгаажуулж холбогдох удирдлагын уялдаа холбоог тодорхойлох;
- Үүрэг, хариуцлагыг шинэчлэх;
- СӨУТ-тэй холбоотой холбогдох стандартуудыг тоймлох;
- Соёлын өвийн удирдлагатай холбоотой “Оюу толгой” компанийн зорилт, үйл ажиллагааны журам, удирдамжийг баталгаажуулах;
- Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт зэрэг хяналт шинжилгээ, тайлагнах үйл явцын журмыг баталгаажуулах;
- Сургалтын шаардлагыг бататгах;
- Холбогдох материал, мэдээллийн эх сурвалжийг тодорхойлох.

1.2. Хэрэглээ

СӨУТ-нд заасан шаардлагууд Оюу Толгой компанийн бүх үйл ажиллагаа төдийгүй гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд хамаарна.

Энэхүү СӨУТ-г 2015 оны 4 дүгээр сарын 1-нд баталсан Рио Тинтогийн Орон нутгийн харилцаа, нийгмийн хариуцлагын стандартад үндэслэн боловсруулсан болно. Уг стандартад орсон өөрчлөлтөд нийцүүлэн энэхүү СӨУТ-нд өөрчлөлт оруулж болно.

1.3. Эхлэх хугацаа

Энэ удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлнэ.

1.4. Эрх, удирдлага

Удирдлагын төлөвлөгөөний шинэчилсэн хувилбарыг “Оюу толгой” компанийн Гүйцэтгэх хороо 2013 оны 9-р сарын 1-нд баталж, 2016 болон 2019 онуудад шинэчилсэн.

“Оюу Толгой” компанийн Орон нутгийн харилцааны хэлтэс (ОНХХ)-ийн Ерөнхий менежер нь СӨУТ-ний хариуцагч байна. Хурдацтай өөрчлөгдөх бизнес, зохицуулалтын болон орон нутгийн нөхцөл байдлаас үүдэн зайлшгүй өөрчлөлт хийх шаардлага үүсэхээс бусад тохиолдолд энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2 жил тутамд хянан үзэж, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг тодорхойлно. СӨУТ-нд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг ОНХХ-ийн Ерөнхий менежерт гаргах ба “Оюу толгой” компанийн Өөрчлөлтийн удирдлагын журамд заасны дагуу хянан үзэж, батална.

¹ http://www.riotinto.com/documents/RT_Management_System_Standard_2015.pdf -с үзэх

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү СӨУТ нь Оюу Толгой компанийн бүх үйл ажиллагааг төдийгүй гэрээт гүйцэтгэгчдийн үйл ажиллагаанд хамаарна. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг Оюу толгойн Соёлын өвийн удирдлагын системийн журмын дагуу хэрэгжүүлнэ. Цаашид шинээр хийх ажлын соёлын өвийн үнэлгээнд ОТ-н Газар хөндөх зөвшөөрөл олгох журам (ОТ-10-Е9-PRC-0003) болон Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хуулийн хүрээнд хийгдэх байгаль орчны үнэлгээг ашиглана.

Гэрээт гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаар Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо баримт бичигт тусгасан болно (ОТ-07-PLN-0001).

2.2. Соёлын өв – Тодорхойлолт

“Оюу толгой” компани нь Рио Тинтогийн тодорхойлсон, тус группийн бүх салбарт нийтлэг хэрэглэгддэг соёлын өвийн дараах тодорхойлолтыг ашигладаг. Тухайлбал:

Соёлын өв гэдэг нь орон нутагт ёс уламжлалын дагуу өв уламжлагдсан буюу түүхэн ач холбогдолтой, орон нутгийнхны нийтээр хүлээн зөвшөөрсөн өвийг хэлнэ. Соёлын өв нь биет буюу барилга байгууламж, үйлдвэрийн байгууламж, технологи, газар нутаг, түүхэн олдворууд болон биет бус, тухайлбал, хэл, зураг, хөгжим, урлаг болон зан заншил байж болно.

Рио тинто соёлын өвийн дурсгал/дурсгалт газрыг дараах байдлаар тодорхойлжээ:

Өнгөрсөн, одоо, ирээдүй үеийн соёлын, сүсэг бишрэлийн, гоо зүйн, түүхэн, шинжлэх ухааны, судалгааны буюу нийгмийн ач холбогдолтой газар буюу эд зүйл. Эдгээрт уламжлалыг өвлөсөн хүмүүст “ариун дагшин” онцгой ач холбогдолтой газар, тухайлбал, оршуулгын газар, тэмдэглэлт үйл явдал зохион байгуулдаг газар, хадны бичээс, нуур цөөрөм, уул даваа буюу домгийн буюу түүхэн үйл явдалтай холбоотой бодит зүйлс багтана. Мөн орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд археологи, үйлдвэрлэл, палеонтологи, түүх, шашин, соёлын ач холбогдол бүхий байгууламж, газар нутаг, археологийн олдвор байж болох ба эдгээр нь хуулийн хүрээнд илүү нарийн тодорхойлогдсон байж болно.

Соёлын өвийн дээрх тодорхойлолтууд нь олон төрлийн биет болон биет бус соёлын өвийн үнэт зүйлс хадгалагдаж буй Өмнийн говийн бүс нутгийн соёлын өвийн үнэт зүйлсэд тохирохуйц тодорхойлолт юм. Энэ бүс нутаг нь соёлын өвийн судалгааны арвин баялаг түүхтэй бөгөөд тэдгээрийн ихэнхийг социализмын үед явуулсан байдаг. 2002 оноос хойш Монгол улсын Шинжлэх Ухааны Академи (ШУА) Оюу Толгой компанийн захиалгаар 80 гаруй соёлын өвийн үнэлгээ (археологийн 48, палеонтологийн 18, угсаатны зүйн 13 судалгаа) хийсэн нь энэ бүс нутгийн соёлын өвийг баримтжуулахад ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Эдгээр соёлын өвийн талаар Оюу толгой компанийн Монголын соёлын өвийн олон улсын баг (МСӨОУБ)-аас гаргасан 1-р шатны тайланд (Өнгөрснийг хамгаалж, өнөөдрийг хадгалах нь: Оюу Толгой төслөөс Өмнөговь аймагт хэрэгжүүлсэн Соёлын өвийн хөтөлбөрийн 1-р шатны үйл ажиллагааны тайлан) дэлгэрэнгүй дурдсан тул энд цухас дурдав.

2.3. СӨУТ-нд орсон соёлын өвийн төрлүүд

Биет бус соёлын өв

Өмнөговь аймагт Монголын уламжлалт ахуй, нүүдлийн мал аж ахуйн хэв маягтай холбоотой онцгой ач холбогдол бүхий биет бус соёлын өвийн үнэт зүйлс их байдаг ба тэдгээрт дуу хөгжим,

“ОЮУ ТОЛГОЙ” ХХК

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

гар урлал, хэл соёл, сүсэг бишрэл, аман түүх болон Монгол бичиг зэрэг багтдаг. Биет бус үнэт зүйлс биетөв болох газар нутаг, эд зүйлстэй холбоотой байх нь бий. Үүнд газар нутгийн байгалийн тогтоц, уул ус (жишээ нь хадны бичээс ихтэй Жавхланта уул) болон хүний гараар бүтсэн зүйлс орно (жишээ нь овоо). Өмнийн говийн бүс нутагт домог, зан заншил, түүхтэй холбоотой ариун дагшин газар олныг олж тогтоосон байна. МСӨОУБ-ийн гүйцэтгэсэн ажлууд биет бус соёлын өвийн үнэт зүйлс нь орон нутгийн ард иргэдэд онцгой ач холбогдолтой болохыг баталгаажуулсан байдаг.

Биет соёлын өв

Биет соёлын өвд археологийн болон палеонтологийн олдворууд багтдаг. Археологийн олдворууд нь Палеолитийн (Чулуун зэвсгийн) үеэс эхлэн төмөр зэвсгийн үеүүдийг хамрах ба, хамгийн ойрын гэвэл 1930-аад онд социалистуудын нураасан шарын шашны сүм хийдийн үлдэгдэл энэ бүс нутагт элбэг тохиолдоно. Палеолитийн үеийн эд өлгийн зүйл бүхий талбай, дөрвөлжин булш, буган хөшөө, хадны зураг, суурин газрын туурь, булш, хөшөө болон шарын шашны сүм хийдийн балгас зэрэг археологийн өргөн хүрээний олдворууд нь түүхийн олон үеийг илтгэнэ.

Өмнийн говийн бүс нутаг нь геологийн олон эрин үеийн байгаль орчин, цаг уурын онцлогийг илэрхийлэх үлэг гүрвэлийн олдвор, чулуужсан модны палеонтологийн баялаг өвтэй гэдгээрээ алдартай. Үлэг гүрвэлийн мөр, яс нэг дороос олдсон онцгой газар болох Шар Цав зэрэг зарим үлэг гүрвэлийн мөрт газрууд нь олон улсад ач холбогдолтойд тооцогддог.

2.4. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү СӨУТ нь Байгаль орчин нийгмийн удирдлагын төлөвлөгөөний цогц баримт бичигт (ОТ-10-PLN-0001-Е) дэлгэрэнгүй тодорхойлсон “Оюу толгой”-д зориулан боловсруулсан Үйл ажиллагааны удирдлагын багц төлөвлөгөөний нэг хэсэг болно.

Энэхүү СӨУТ-нд дор дурдсан хэд хэдэн Удирдлагын төлөвлөгөөтэй давхцсан, харилцан уялдаатай хэсгүүд бий. Тэдгээрт:

- Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0001), ялангуяа Газар хөндөх зөвшөөрөл олгох системийг хэрэгжүүлэх холбоотой хэсэг;
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001-Е), түүний дотор Ундай гол, Бор Овоогийн булагтай холбоотой хэсэг;
- Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө (ОТ-10-PLN-0003-Е), түүний дотор орон нутагтай зөвшилцөх шаардлагатай холбогдох хэсэг;
- Гүйцэтгэгчийг удирдах тогтолцоо (ОТ-07-PLN-0001), түүний дотор гүйцэтгэгчийн СӨУТ-өөр гүйцэтгэгчид тавьдаг шаардлагатай холбоотой хэсэг;
- Хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0004-Е), түүний дотор биет бус соёлын өв, амьдралын уламжлалт хэв маягийг хадгалах, хамгаалахтай холбогдох хэсэг;
- Агаарын бохирдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е2-PLN-0001-Е), түүний дотор тоосны хяналттай холбогдох хэсэг;
- Хөдөлмөр эрхлэлтийн удирдлагын төлөвлөгөө (HR-10-PLN-0001-Е), ялангуяа Кэмгийн стандарт болон Ёс зүйн дүрэм (HR-ST-01)-тэй холбогдох хэсгүүд; болон
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө багтана.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-E	Хувилбар: 1.3

3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1. СӨУТ- ний хэрэгжилтийг хариуцах гол албан тушаалтан, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

СӨУТ-г хэрэгжүүлэх гол албан тушаалтан, тэдгээрийн гүйцэтгэх үүргийг 1-р Хүснэгтэд үзүүлэв.

1-р Хүснэгт. Хариуцах гол албан тушаалтан, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Албан тушаал	Үүрэг хариуцлага
ОНХХ-ийн Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> СӨУТ, түүний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцна.
Орон нутгийн тусламж, хамтын ажиллагаа хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> СӨУТ-ний талаар бүрэн дүүрэн ойлголттой байж, түүнийг хэрэгжүүлэхэд зохистой нөөцийг бүрдүүлэх СӨУТ-ний хэрэгжилтийн талаар Оюу толгойн ажилтнуудтай харилцах гол ажилтан байна. Соёлын өвийн үнэлгээг гүйцэтгэх Соёлын өвийн талбайг хамгаалах тухайлсан/тусгай төлөвлөгөө боловсруулах Холбогдох төрийн байгууллагууд, орон нутгийн иргэдийн бүлгүүдтэй зөвлөлдөх, соёлын өвийн холбогдох зөвшөөрлийг авах Зохих зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагааны улмаас соёлын өв бүхий газруудыг хөндүүлэхгүй байх Соёлын өвийг хөндөж болзошгүй ажилд оролцох ажилтнуудыг шаардлагатай сургалт, танилцуулах сургалтад хамруулж тэдэнд соёлын өвийн талаарх үүрэг хариуцлагыг нь ойлгуулах
Орон нутгийн эрх зүй, удирдлага зохицуулалт хариуцсан менежер	<ul style="list-style-type: none"> СӨУТ-ний хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах СӨУС, СӨУТ-г боловсруулж хэрэгжүүлэх СӨУТ-г тогтмол шинэчлүүлэх Аудит, хяналт шалгалтын бэлтгэлийг хангах, зохицуулалт хийх Газар хөндөх зөвшөөрлийн соёлын өвийн бүрэлдэхүүн хэсгийг хариуцах Соёлын өвийн Газар зүйн мэдээллийн системийн мэдээлэлийг шинэчлүүлэх, тэдгээрийг Газар хөндөх зөвшөөрлийн үйл явц зэрэг ОТ-н бизнесийн үйл ажиллагаатай уялдуулах Соёлын өвийг зөвшөөрөлгүйгээр хөндөх, дүрэм журмыг зөрчих тохиолдлыг илрүүлэх, тайлагнах, дараагийн арга хэмжээг авах Шинээр газар хөндөх шаардлагатай ажлын талбайд соёлын өвийн судалгаа, хяналт шинжилгээ хийлгэх Хууль журам, бодлогын өөрчлөлтийг удирдан зохицуулах

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-E	Хувилбар: 1.3

ОТ удирдах ажилтнууд(ялангуяа уурхайн талбайн гадна хэрэгжих үйл ажиллагаа хариуцсан)	<ul style="list-style-type: none"> ОТ-н СӨУС-ний талаар ойлголттой байж, түүнийг хэрэгжүүлэх-ялангуяа Газар хөндөх зөвшөөрлийн журмыг мөрдөхдөө соёлын өвийн холбогдолтой тулгарч болзошгүй асуудлыг шалгах хуудсаар тодорхойлох, соёлын өвийн болзошгүй нөлөөллийг бууруулахад чиглэсэн үнэлгээ явуулах ажилд холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулахад заавар чиглэл өгөх
Гэрээт Гүйцэтгэгчид	<ul style="list-style-type: none"> СӨУТ-ний холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх Гүйцэтгэгчдийн гэрээнд заасан СӨУТ-ний шаардлагуудыг биелүүлэх
ОТ-н ажилтнууд	<ul style="list-style-type: none"> Сургалт, танилцуулах сургалтуудад хамрагдаж СӨУТ-ний дүрэм журмын талаар мэдлэг мэдээлэлтэй байх

3.2. Соёлын өвийн гол оролцогч талууд

Өмнөговь аймгийн соёлын өвийн гол оролцогч талуудыг 2-р хүснэгтэд харуулав.

2-р Хүснэгт. Соёлын өвийн гол оролцогч талууд

Оролцогч тал	Үйл ажиллагааны чиглэл/харилцаа хамаарал
Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам	Салбарыг хамарсан хууль тогтоомж, бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, хянах, соёлын өвтэй холбоотой үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Монгол улсын Яам.
Монгол улсын Шинжлэх Ухааны Академи (тэр дундаа, Түүх, археологи, геологийн хүрээлэн)	Монгол улсад шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх, шийдвэр гаргагч төрийн байгууллагуудад шинжлэх ухааны үүднээс зөвлөгөө өгөх үүрэгтэй эрдэм шинжилгээний байгууллага
Өмнөговь аймаг болон сумын төрийн захиргааны байгууллагууд (бусад холбогдох байгууллага)	Соёлын өвийн бодлогын хэрэгжилтийг хариуцсан бүс, орон нутгийн байгууллагууд. Үүнд орон нутгийн төрийн байгууллагын санхүүгийн болоод материаллаг нөөцийг удирддаг байгууллагууд хамаарна.
Иргэний нийгмийн байгууллагууд	Монгол улсын соёлын өвийн ерөнхий удирдлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажилладаг мэргэжлийн холбоо, орон нутгийн ТББ, ашгийн бус хувийн байгууллагууд
Хамтын ажиллагааны хороо	Хамтын ажиллагааны хороо нь ХАГ-ний хүрээнд ОТ, Өмнөговь аймаг, түншлэгч сумд хоорондын хамтын ажиллагаанд ерөнхий хяналт тавина. Энэ ажлын хүрээнд нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэдийн төлөөлөл, ОТ-н үйл ажиллагаа хариуцсан ахлах менежерүүд тогтмол уулзаж, ОТ төслийн Өмнөговь аймаг болон Түнш сумдын ард иргэдэд үзүүлсэн, үзүүлж буй, цаашид үзүүлэх нөлөөллийг хэлэлцэж, үнэлж дүгнэдэг форум зохион байгуулдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг Оюу толгой - Өмнөговь аймгийн ХАГ-ний 2-р Нэмэлт хавсралтаас үзнэ үү.
Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан (ХДС)	ХДС нь Оюу толгой-Өмнөговь аймаг хоорондын Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд 2015 оны 9-р сард бие даасан хуулийн этгээд болж байгуулагдсан ба Өмнөговь аймаг, түншлэгч сумдын тогтвортой хөгжлийг дэмжихэд хувь нэмэр оруулах зорилготой. Оюу толгой - Өмнөговь аймгийн ХАГ-ний 3-р Нэмэлт хавсралтаас үзнэ үү.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2019.01.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-E	Хувилбар: 1.3

Гурван талт зөвлөл	Ханбогд сумын малчид, төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, ОТ-н менежерүүдийн оролцоо бүхий энэхүү албан ёсны хороо нь Ханбогд сумын малчид болон ОТ компани хоорондын хамтын ажиллагаа тэр дундаа соёлын өвтэй холбоотой асуудлуудаар хяналт тавьж ажиллана.
--------------------	---

3.3. Гол үүрэг гүйцэтгэгчид

СӨУТ-г хэрэгжүүлэх гол үүрэг гүйцэтгэгчид нь :

- Байгаль орчин, Биологийн олон янз байдал хариуцсан баг, тэр дундаа газар хөндөх зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд оролцогчид;
- Сургалтын баг, ялангуяа Соёлын өвийг хамгаалах, хадгалах тухай танилцуулах сургалт явуулах/сургалттай холбоотой ажилтнууд;
- Засгийн газартай хамтран ажиллах баг, ялангуяа Говийн соёлын өвийн судалгааны төвийн чиглэлээр Засгийн газартай харилцах баг;
- Кэмп, уурхайн үйлчилгээ, Хүний нөөц, Гэрээт байгууллагын хамтын ажиллагааны багууд, ялангуяа Оюу Толгойн Кэмпийн стандарт, Ёс зүйн дүрэм (HR-ST-01) –ийг хэрэгжүүлэхтэй холбогдох ажилтнууд
- Тээвэр хариуцсан менежер, ялангуяа тээврийн хяналт удирдлагын ажилтнууд байна.

3.4. Холбогдох стандартуудын тойм

ОТ ХХК нь Монгол улсын стандартууд, зээлдүүлэгчээс тавих стандарт болон Рио Тинтогийн холбогдох стандартуудаас аль шаардлага өндөртэйг нь дагаж мөрдөхийн зэрэгцээ ОТ-н стандартуудаас аль шаардлага өндөртэйг нь дагаж мөрддөг ба тэдгээрийг 3-р хүснэгтэд тоймлон харуулав.

3-р Хүснэгт. Соёлын өвийн холбогдох стандартууд

ОТ-н хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт	Шаардлага
Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль	Эрдэсийн хайгуул, уурхайн бүтээн байгуулалтын ажил хийхийн өмнө эрх бүхий байгууллагаар археологийн хайгуул, судалгаа хийлгэх шаардлага тавина. Эрх бүхий археологийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Соёлын өвийн ач холбогдолтой эд зүйлс олдсон, эрсдэлд орсон байж болзошгүй тохиолдолд тухайн сумын засаг даргад даруй мэдэгдэж, тус газрыг хамгаалалтад авах шаардлагатай. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамны тодорхой зөвшөөрөлгүйгээр соёлын болон өвийн ач холбогдол бүхий үл хөдлөх эд зүйлсийг малтах, шилжүүлэн байршуулах, нураахыг хориглоно.
Монгол улсын Ашигт малтмалын тухай хууль	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуул, уурхайн үйл ажиллагааны улмаас түүхийн болон соёлын өвд хохирол учруулсан бол тухайн өв эзэмшигч, хэрэглэгчид хохирлыг бүрэн нөхөн төлнө.

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-E	Хувилбар: 1.3
Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шаардлага	Хамгаалалтын хашаа барих, СДЗОТБЖ хэрэгжүүлэх, гэрээт гүйцэтгэгч нарт соёлын өв, СДЗОТБЖ-ын талаар сургалт зохион байгуулах	
Дэлхийн өв хамгаалах тухай конвенци	Монгол улсын Засгийн газар Дэлхийн өв хамгаалах тухай конвенцид нэгдсэн. Хэдийгээр уг конвенци ОТ-д шууд хамааралгүй ч, тус Конвенцийн зарчмууд нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бодлогоор дамжин Монгол улсад хэрэгждэг. Конвенцид нэгдэн орсноор Монгол улсын Засгийн газар өөрийн нутаг дэвсгэр дэх Дэлхийн өв бүхий газар нутаг, үндэсний өвөө хамгаалах үүрэг хүлээсэн байдаг. Мөн соёлын болоод байгалийн өв хамгаалах ажлыг бүсийн төлөвлөлтийн хөтөлбөрт оруулах, эдгээр өв бүхий холбогдох газарт өвийг хамгаалах боловсон хүчин, үйлчилгээг бий болгох, шинжлэх ухаан, техникийн судалгаа хийх, нутгийн иргэдийн өдөр тутмын амьдралд холбогдох өв соёлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг тусгах ажлуудад дэмжлэг үзүүлнэ.	
Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенци	Монгол улс “Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенци”-д нэгдэн орсон. Хэдийгээр уг конвенци ОТ-д шууд хамааралгүй ч, тус Конвенцийн зарчмууд нь Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бодлогоор дамжин Монгол улсад хэрэгждэг. Конвенцид нэгдэн орсноор Монгол улсын Засгийн газар өөрийн нутаг дэвсгэр дэх соёлын биет бус өвийг i) өөрийн нутагт байх соёлын биет бус өвийн олон төрөл зүйлийг тодорхойлох, тэдгээрийг хамгаалах чадавхитай этгээдийг томилох ii) соёлын биет бус өвийг удирдах, баримтжуулах, ашиглах зөвшөөрөл олгох зохих хууль эрхзүй, санхүүгийн болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэх замаар хамгаалах үүрэг хүлээсэн.	
ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 8: Соёлын өв	<p>ОУСК-ийн Гүйцэтгэлийн 8-р стандарт:</p> <ul style="list-style-type: none"> • Төслийн байршил тогтоох, төлөвлөлт хийхдээ соёлын өвд ноцтой хохирол учруулахаас зайлсхийх. • Төсөл нь (багууд) Соёлын өвийн ач холбогдлыг тодорхойлох, энэ талаар орон нутгийн иргэдийн санал бодлыг шийдвэр гаргах үйл явцад тусгах зорилгоор нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэд, холбогдох захиргааны байгууллагуудтай хэлэлцүүлэг хийнэ. • Гүйцэтгэгч/Хэрэгжүүлэгч нь Соёлын дурсгалт зүйлс олдсон тохиолдолд баримтлах журмыг боловсруулж, хэрэгжүүлэх. • ‘Нэн чухал соёлын өв’-ийг их хэмжээгээр өөрчилж, гэмтээж, зөөвөрлөж болохгүй. • Нутгийн иргэдэд хадгалагдаж буй биет бус соёлын өвийг арилжаа, сурталчилгааны зорилгоор ашиглах бол орон нутгийн иргэдтэй хэлэлцэж зөвшилцөн, зөвшөөрөл авч, ач тусыг таниулах. 	
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 8: Соёлын өв	<p>ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн 8-р шаардлагын зорилтууд:</p> <ul style="list-style-type: none"> • ЕСБХБ-ны хөрөнгө оруулалттай төслүүдэд соёлын өвийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх • Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах • Соёлын өв ашиглуулснаас олсон ашиг орлогын тэгшхуваарилалтыг дэмжих • Соёлын өвийн тухай ойлголт мэдлэгийг дээшлүүлж, түүнд хүндэтгэлтэй хандах 	

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3
Рио Тинтогийн Орон нутаг, нийгмийн хариуцлагын стандарт (Заалт 1.6)	<p>Соёлын өвийг тухайн орон нутагтай зөвшилцсөний үндсэн дээр удирдана. Соёлын биет өвийн эд зүйлс, соёлын биет бус өвийн ойлголтуудыг баримтжуулах шаардлагатай. Баримтжуулсан соёлын өвийг удирдан зохицуулахын тулд бизнесийн бүх нэгжүүд дараах шаардлагыг хангасан байх ёстой ба үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Зорилгод нийцсэн Соёлын өвийн удирдлагын систем боловсруулж, хэрэгжүүлэх; • Үйл ажиллагааг төлөвлөх, байршил тодорхойлохдоо сэргээн засварлах боломжгүй соёлын өвийг аль болох гэмтээхээс зайлсхийх; • Соёлын өвийг хөндөхөөс зайлсхийх аргагүй бол тухайн соёлын өвд хамааралтай оролцогч талуудаас зохих зөвшөөрөл авах; • Үйлдвэрийн болон түүхэн соёлын өв, бизнесийн үнэ цэнийн асуудалд ялангуяа уурхай хаах үед анхаарал хандуулах; • Орон нутгийн соёлын биет үнэт зүйлс бизнесийн үйл ажиллагааны улмаас гарч байгаа өөрчлөлтөд анхаарал хандуулах; 	

3.5. Хамтын ажиллагааны гэрээний соёлын өвтэй холбоотой үүрэг амлалтууд

3-р Хүснэгтэд жагсаасан гадны стандартуудаас гадна ОТ компани Өмнөговь аймагтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээндээ (ХАГ) соёлын өвийг хамгаалах талаар үүрэг амлалтуудыг тусгасан. Өмнөговь аймгийн Ханбогд сумын удирдлагатай Оюу толгой компани нь хамтын ажиллагааны үндсэн зорилтуудыг тодорхойлсон Харилцан ойлголцлын санамж бичигт 2011 оны 4-р сард гарын үсэг зурснаар Хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл явцын эхлэл тавигдсан. Хэлцэлхийх зарчим, гол журмуудыг тусгасан Үйл явцын гэрээг 2012 оны 9-р сард байгуулсан ба Хамтын ажиллагааны үндсэн гэрээнд Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын удирдлага болон Оюу толгой компани 2015 оны 4-р сарын 22-нд үсэг зурсан.

ХАГ-нд Өмнөговь аймаг, Ханбогд болон бусад түншлэгч сумдын тогтвортой хөгжлийн төлөө талууд хэрхэн хамтран ажиллах талаар тусгасан бөгөөд дараах гол чиглэлүүдийг тодорхойлсон:

- Усны менежмент – Нэмэлт хавсралт 4
- Байгаль орчны хяналт-шинжилгээ, хамгаалал – Нэмэлт хавсралт 5
- Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент – Нэмэлт хавсралт 6
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал – Нэмэлт хавсралт 7
- Нийгмийн суурь үйлчилгээ (Эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт) – Нэмэлт хавсралт 8
- Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, бараа, үйлчилгээ худалдан авах – Нэмэлт хавсралт 9
- Нийтийн зориулалттай дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төсөл – Нэмэлт хавсралт 10

3.6. Хамтын ажиллагааны Нэмэлт хавсралт 7: Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал

ХАГ-ний энэхүү нэмэлт хавсралтад соёлын өвтэй холбоотой хамтран ажиллах чиглэлүүдээр ОТ, орон нутгийн захиргааны байгууллагуудын харилцан хүлээсэн үүрэг, амлалтуудыг тодорхойлсон болно.

Амлалт

ОТ ХХК нь үндэсний түүх, соёл, аялал жуулчлал, Түнш сумдтай холбоотой дараах амлалтыг өгсөн болно:

- Түнш сумдын соёлын өвийг хамгаалахтай холбоотойгоор Монгол улсын Соёлын өвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын шаардлагуудыг дагаж мөрдөх.
- ОТ төслийн бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн явцад соёлын өвийг хамгаалах СӨУТ, СӨУС –

Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөө		
Хүчинтэй болох: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10--PLN-0002-Е	Хувилбар: 1.3

г хэрэгжүүлэх.

Үүрэг

Талууд (Өмнөговь аймаг, Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сум, ОТ ХХК) СӨУТ-тэй холбоотой дараах үүргүүдийг хүлээхээр харилцан тохиролцсон болно. Үүнд:

- Өмнөговь аймгийн түүх, соёлын өвийг хадгалах, сурталчлах арга замыг тодорхойлох чиглэлээр Талууд хоорондоо болон бусад талуудтай хамтран ажиллах;
- Түнш сумдын биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ОТ-н Соёлын өвийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр талууд хоорондоо болон Монгол улсын Засгийн газрын төрийн эрх барих холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.
- Өмнөговь аймаг өөрийн нутаг дэвсгэрт байх байгалийн өв, биет болон биет бус соёлын өвийг хамгаалах ажлыг чиглүүлж, удирдана.
- Өмнөговь аймгийн түүх, соёлын өвийн судалгааг хамгаалах, сурталчлах зорилготой “Говийн соёлын өвийн судалгаа, хөгжлийн төв” байгуулах, түүнийг байнгын ажиллагаатай (холбогдох талуудын хамтын ажиллагааг хангах, зохион байгуулах) байлгахад Өмнөговь аймаг идэвхитэй оролцоно.
- Талууд “Хөгжлийг дэмжих сан”-гаас дэмжлэг авах шалгуур хангах боломжтой төсөл, хөтөлбөрийг тодруулахад хамтран ажиллаж, түнш сумдын “ахуй соёлыг” хадгалах, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий, боломжит төслийн саналыг дэмжихэд Хамтын ажиллагааны хороогоор дамжуулан хамтарч ажиллах.
- ОТ ХХК нь аливаа төлөвлөгөөт малталт хийх буюу шинэ газарт уул уурхайн үйл ажиллагаа явуулахаасаа өмнө Хамтын ажиллагааны хороо, Түншлэгч сумд, Түүх, археологийн хүрээлэн, Палеонтологийн хүрээлэнд тус тус мэдэгдэнэ.
- ОТ ХХК-ийн газар хөндөх журам нь зураг төсөл, байршлыг өөрчлөх зэргээр газар хөндөхөөс зайлсхийх боломжтой эсэхийг тогтоохын тулд археологи, палентологи, угсаатан зүйн өвийг хамгаалах урьдчилсан судалгаа явуулахыг шаардана.
- ОТ ХХК нь барилгын зураг төсөл, байршлуудыг тодорхойлохдоо түүх, соёлын ач холбогдолтой гэж тогтоосон газруудад үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, түүнийг хамгийн бага хэмжээнд байлгах хувилбарыг сонгоно.
- ОТ ХХК нь өөрийн хэрэгжүүлэх түүх, угсаатан зүйн аливаа судалгаанд Түүх, археологийн хүрээлэнг оролцуулна.
- ОТ ХХК нь Хамтын ажиллагааны гэрээнд хамаарах орон нутагт орших үе дамжин ирсэн ариун дагшин газруудын (үүнд байгалийн тогтоц, нутгийн ард иргэдийн хүндэтгэн дээдэлж, сүсэглэн биширдэг уул, рашаан зэрэг газрууд, овоо, тахилга, оршуулгын газар гэх мэт) жагсаалтыг хөтөлж, Хамтын ажиллагааны хороо, Түншлэгч сумдад өгнө. Эдгээр газруудтай холбоотой домог, цээрлэдэг зүйлс, зан үйл зэргийг мөн тэмдэглэж болно.
- ОТ ХХК нь газар чөлөөлөх буюу холбогдох барилгын үйл ажиллагааны явцад "Соёлын дурсгалт зүйлс олдсон тохиолдолд баримтлах журам"-ыг баримтлах ба Түүх, археологийн хүрээлэн эсвэл Палентологи, геологийн хүрээлэн өвийг авран хамгаалах малталт хийх шаардлагатай гэж тодорхойлсон тохиолдолд уг ажлыг зохион байгуулна.
